



АРХАНГАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 40

Эрдэнэбулган сум

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд  
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь, Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөр”-ийг баталсугай.

2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн Орон нутгийн төсөвт тусган батлуулж, хэрэгжилт, үр дүнг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /Ц.Мөнхнасан/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ӨСӨХБАЯР

652000111

## АРХАНГАЙ АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР /2020-2024/

### Нэг. Дэд хөтөлбөрийн ерөнхий мэдээлэл

Архангай аймгийн хүн ам 2018 оны жилийн эцсийн байдлаар 95,9 мянга болж 2017 оны хүн амын тоотой харьцуулж үзвэл 1.1 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Нийт хүн амын 50.1 хувийг эрэгтэйчүүд, 49.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Архангай аймгийн хувьд 2016 онд эрэгтэй хүний дундаж нас 68.31 байсан бол 2018 онд 68.63 болж 0.32 насаар, 2016 онд эмэгтэй хүний дундаж нас 72.27 нас байсан бол 2018 онд 73.08 болж 0.81 насаар тус тус нэмэгдсэн байна. 2018 оны байдлаар эмэгтэйчүүдийн дундаж наслалт улсын дунджаас 2.7 насаар бага, эрэгтэйчүүдийн дундаж нас 2.52 насаар бага байна.

2017 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 3513 байсан бол 2018 онд 3523 болж 10 хүнээр нэмэгдсэн байна. Үүний 57,9 хувь нь /1451/ эмэгтэйчүүд байна.

2018 онд өрх толгойлсон хүний тоо 3343 байгаагаас 74.3 хувийг /2484/ өрх толгойлсон эмэгтэйчүүд эзэлж байна.

2018 онд 609 хүн нас барсны 57.5 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. 2018 онд хорт хавдрын өвчнөөр нас баралт 132 тохиолдол байна.

2018 онд нийт 254 эмэгтэй үр хөндүүлснээс 144 /56.6%/ тохиолдол нь 15-34 насны залуу охид эмэгтэйчүүдийн үр хөндөлт эзэлж байна.

2018 оны байдлаар гэмт хэрэгт холбогдсон хүний тоо 257 байгаагийн 236 /91.8%/ нь эрэгтэйчүүд, 21 /8.2%/ нь эмэгтэйчүүд эзэлж байна. Гэмт хэрэгт өртөж хохирсон хүний тоо 527 байгаагаас эмэгтэй 184, 18-аас доош насны хүүхэд 13 байсан бол гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо 11, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг-12 гарсан байна.

Манай аймгийн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг түр хамгаалах байраар 2019 онд нийт 21 хүн үйлчлүүлсэн байна. Үүний 5 нь насанд хүрэгч, 16 хүүхэд байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд 2017 онд 5, 2018 онд 11,

2019 онд 5 байна. Хүүхдийн хууль зүйн хороогоор үйлчлүүлсэн хүүхдийн тоо 2019 онд 17, үүний 8 нь Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэй хүүхэд байна.

2018 оны байдлаар аймаг, сумын ИТХ-ын дарга нарын 25 хувь, аймгийн ИТХ-ын 39 төлөөлөгчдийн 15 хувь нь, сумдын ИТХ-н төлөөлөгчдийн 23.5 хувь нь, аймгийн ЗДТГ-ын 7 хэлтсийн даргын 2, төрийн байгууллагын удирдах албан тушаалтны 18 хувь нь тус тус эмэгтэйчүүд байна. ЕБС-ийн захирлуудын 48.5 хувь, нийт ажиллагчдын 81 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч нар 100 хувь эмэгтэйчүүд байна. Иймээс төрийн байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсч байна.

Аймгийн хөгжлийн бодлогын 14 баримт бичиг, дэд хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийж жендэрийн асуудалд хамаарах байдлаар нь авч үзэхэд: Зорилтуудын 0.2 хувь, үйл ажиллагааны 1.8 хувь нь жендэрийн мэдрэмжтэй төлөвлөгдсөн байгаа нь орон нутгийн бодлогын баримт бичгүүдэд жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт хангалтгүй байгааг харуулж байна.

Дээрх тоо баримтуудад дүн шинжилгээ хийж үзэхэд жендэрийн тэгш байдлыг хангах хуулийг хэрэгжүүлэх орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, хүн амын хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг хийх, хэрэгжүүлэх, хянах, иргэд олон нийтийн оролцоонд тулгуурласан салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, статистик үзүүлэлтийг гарган олон нийтэд хүргэх шаардлагатай байгаа тул орон нутгийн онцлогт тохирсон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулав.

Дэд хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд *“Архангай аймгийн жендэрийн нөхцөл байдал”* үнэлгээг аймгийн ЛЭОС төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж үнэлгээний тайланд олон нийтийг жендэрийн ойлголттой болгох, аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналт үнэлгээнд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх, орон нутгийн жендэрийн тэгш байдлыг хангах тогтолцооны чадавхийг бүрдүүлэх, түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх, жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага тавигдаж байна гэж дүгнэгдсэн.

Аймгийн хэмжээнд жендэрийн тэгш байдлыг хангахад жендэрийн асуудлаарх мэдлэг, ойлголт дутмаг, байгууллагуудын хамтын ажиллагаа сул, тогтолцооны хувьд чадавхигүй байгааг харгалзан бодлогын бичиг баримттай

болох шаардлагатай хэмээн үзэж аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19-р заалт, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээ авах тухай Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоол, Засгийн газрын болон аймгийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, Жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээний тайлангийн үр дүнтэй уялдуулан боловсруулав.

#### **Дэд хөтөлбөр хэрэгжүүлэх үндсэн зарчим**

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах
- Ялгаварлан гадуурхахгүй байх
- Төрийн хариуцлага, хяналт
- Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлт
- Жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх

#### **Хамрах хүрээ**

- Бүх насны иргэд
- Бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллага /баг, сум, аймаг/
- Бүх шатны захиргааны байгууллага /баг, сум, аймаг/
- Хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд
- Хэвлэл мэдээллийн байгууллагууд

#### **Хоёр. Дэд хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа**

##### **2.1 Дэд хөтөлбөрийн зорилго**

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлж жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг боловсруулан хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засаг, улс төр, соёл, гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бүх нийтэд жендэрийн боловсрол олгох цогц арга хэмжээ, жендэрт суурилсан хүчирхийлэл ялгаварлан гадуурхахтай тэмцэх урьдчилан сэргийлэх хэрэгжүүлэхэд энэхүү дэд хөтөлбөрийн зорилго оршино.

##### **2.2 Хөтөлбөрийн зорилт**

2.2.1 Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлэхэд Төр, Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг сайжруулах



2.2.2 Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлж тогтвортой байдлыг хангах

2.2.3 Нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, гэр бүлийн харилцаанд эрэгтэй эмэгтэй хүний жендэрийн эрх тэгш оролцоог хангаж, хөгжлийн үр шимээс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх

2.2.4 Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх

2.2.5. Ажил ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангасан орчныг төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжид бүрдүүлэх

### **2.3 Хөтөлбөрийн хамрах хүрээ, хэрэгжих хугацаа**

2.3.1.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх төрийн болон аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллага, иргэдийг хамруулна.

2.3.2 Хөтөлбөрийг 2020-2024 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

### **Гурав . Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

3.1. Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлэхэд Төр, ИНБ-ын түншлэлийг сайжруулах

3.1.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн тэгш оролцоог хангасан тогтвортой ажиллах салбар хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг дэмжих;

3.1.2. Орон нутгийн хөгжлийн бодлого, байгууллагын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, дэд хөтөлбөр, төслийг жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх

3.1.3. Аймгийн засаг даргын байгууллагын удирдлагуудтай хийх үр дүнгийн гэрээнд тусгаж оруулах

3.1.4 Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй болгох, шийдвэр гаргах түвшинд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах.

3.1.5 Улс төрийн болон, төрийн захиргааны удирдах албан тушаалд ЖЭТБХТХ-д заасан квотыг хэрэгжүүлэх

3.1.6 Жендэрийн статистик мэдээллийн нэгдсэн санг орон нутгийн түвшинд салбар бүрээр бүрдүүлэн бодлого төлөвлөлтөд ашиглах

3.1.7 Жендэрийн тэгш байдлыг хангах ажлыг сум, баг, байгууллагын түвшинд хөхүүлэн дэмжиж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

3.1.8 Иргэний нийгмийн байгууллагуудыг жендэрийн дүн шинжилгээ, нөлөөлөл, мониторингийн чиглэлээр мэргэшүүлэн, тогтмол ажиллуулах

### **3.2.Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөлийн цогц арга хэмжээг хэрэгжүүлж тогтвортой байдлыг хангах**

3.2.1.Орон нутгийн төрийн удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчид болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд зориулсан жендэрийн сургалтын модуль боловсруулж, хэрэгжүүлэх

3.2.2.Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүчирхийлэлгүй орчинг дэмжих, хүүхэд, оюутан залуус, гэр бүлд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх Охид, эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх

3.2.3. Олон нийтэд жендэрийн тэгш байдлын талаар мэдээлэл хүргэх, жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэсэн хэвлэл мэдээллийн ажил өрнүүлж, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх

### **3.3. Нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, гэр бүлийн харилцаанд эрэгтэй эмэгтэй хүний жендэрийн эрх тэгш оролцоог хангаж, хөгжлийн үр шимээс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх**

3.3.1.Эрчүүдийн кабинетын үйл ажиллагааг өргөжүүлэх мэс заслын тоног төхөөрөмжөөр хангах

3.3.2 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагааг чанаржуулж, жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэрт өртсөн хохирогчдын тоог бууруулах;

3.3.3.Жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн, нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоог хангахад залуучуудын манлайллыг дэмжих

3.3.4.Бүх нийтийн биеийн тамир, спортын үйл ажиллагааны хүртээмжийг сайжруулж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг тэгш хамруулах, спортоор дамжуулан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах

3.3.5.Урлаг, соёлын байгууллагууд уран бүтээлээрээ гэр бүлийн хүчирхийлэл, үүний шалтгаан, үр дагаврын талаарх мэдлэг мэдээллийг түгээх, жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад нөлөөлөх

3.3.6.Эрэгтэйчүүдийн дундаж наслалт, хорт хавдар, нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлс, нийгэм, соёл, эдийн засгийн идэвхи оролцоо, тэднийг үнэлэх

үнэлэмж, хандлага, гэр бүлийн хүрээнд тулгамдаж буй асуудалд судалгаа хийж нөхцөл байдлыг сайжруулах;

#### **Дөрөв. Хүрэх үр дүн**

- 4.1 Жендэрийн тэгш байдлыг хангах аймгийн хэмжээний тогтолцоо бүрдэнэ.
- 4.2 Төрийн байгууллагуудын жендэрийн асуудлаарх бодлого боловсруулах, төлөвлөх, үнэлэх чадавхи сайжирч, байгууллагын удирдах ажилтнууд 40 хувь нь жендэрийн сургалтад хамрагдсан байна.
- 4.3 Жендэрийн талаарх олон нийт, иргэдийн хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгдсөн байна.
- 4.4 Жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг буурсан байна.
- 4.5 Эрэгтэйчүүдийн кабинетын үйл ажиллагаа өргөжиж, өвчлөл буурна.
- 4.6 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлтүүд сайжирч, дундаж наслалт нэмэгдэнэ.

#### ***Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт***

Дэд хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрүүдээс бүрдүүлнэ.

- 5.1.Улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө
- 5.2.Олон улсын байгууллага болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
- 5.3.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж
- 5.4 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр нарийвчлан гаргаж, голлон хэрэгжүүлэгч болон хариуцсан хэрэгжүүлэгч байгууллагуудыг тодорхойлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.
- 5.5 Түүнчлэн тухайн салбар, орон нутагт хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлдэг хамтын гэрээ байгуулсан Олон улсын болон бусад байгууллагуудын салбарын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, дэмжлэгийнхээ тодорхой хувийг тус дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлнэ.

#### **Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, хэрэгжилтийн тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээ**

6.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Жендэрийн салбар хороо удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулна. Жендэрийн салбар хороо хөтөлбөрийг



хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, шаардлагатай төсвийг жил бүр боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөний хүрээнд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, салбар хороог мэргэжил, арга зүй, удирдамжаар ханган хамтран ажиллана.

6.2.Аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга болон байгууллагын дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд жендэрийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх заалтыг тусган, хэрэгжилтийг үнэлнэ.

6.3.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг жилд нэг удаа аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэстэй хамтран хийж тайлангийн биелэлтийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулан, Жендэрийн үндэсний хорооны ажлын албанд хүргүүлнэ.

6.4 Хөтөлбөрийн үр дүнгийн хөндлөнгийн үнэлгээг хөтөлбөр хэрэгжих сүүлийн жилд нэг удаа орон нутгийн иргэний нийгэмлэгийн байгууллагын төлөөллөөр хийлгэж, үнэлгээний үр дүнг Засаг даргын Тамгын газарт танилцуулна.

6.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын Нийгмийн бодлогын хэлтэс албан ёсны цахим хуудас, олон нийтийн сонин, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

#### Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь түвшин /2019 он/	Хүрэх түвшин	
				2021-2022 он	2023-2024 он
<b>Зорилт 1.</b> Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлэхэд Төр, Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг сайжруулах					
1.	Орон нутгийн жендэрийн нөхцөл байдалд хийсэн үнэлгээ	тоо	1	1	2
2.	Жендэрийн мэдрэмжтэй орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн тоо	Тоо	3	5	8
3.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр сайн туршлага бий болгосон аж ахуй нэгж байгууллагын тоо	тоо	2	2	3
4.	Шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдийн хувь	Хувь/ тоо	111/23.5	25.2	26.3
5	ЖЭТБХТТХ-д заасан ажлын байрыг аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах заалтыг байгууллагын дотоод журамд тусгасан аж ахуй	Тоо	9	13	23



	нэгж байгууллагын тоо				
5.	Жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд орон нутгийн ИНБ-аас хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тоо	тоо	1	1	1
<b>Зорилт 2.</b> Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлж тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд:					
1.	Бүх нийтийн жендэрийн ойлголтыг нэмэгдүүлэх сургалтын удирдамж, нөлөөллийн ажил	тоо	0	23	36
2.	Жендэрийн орон нутгийн сургагч багшийн тоо	тоо	4	2	6
3.	Жендэрийн сургалтад хамрагдсан удирдах ажилтан /УА/, төрийн албан хаагч /ТЖАХ/-ийн тоо	Тоо	0	УА-70 ТЖАХ-150	УА-100 ТЖАХ-250
4.	Явцын болон хөндлөнгийн үнэлгээ, судалгаанаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлсэн ажил	тоо	0	2	4
<b>Зорилт 3.</b> Нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, гэр бүлийн харилцаанд эрэгтэй эмэгтэй хүний жендэрийн эрх тэгш оролцоог хангаж, үр шимээс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:					
1.	Эрэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг кабинетийн тоног төхөөрөмжийн хангалт мэс заслын тоног төхөөрөмж	тоо	0	0	1

-----oOo-----

**“АРХАНГАЙ АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ ТООЦОО**

Бодлогын зорилго, зорилт	Эхлэх/ дуусах огноо	Нийт дүн	2020			2021			2022			2024		
			Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт
<b>Зорилт 1: Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлэхэд Төр, Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг сайжруулах</b>														
Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих	2020-2024	15.0	-	-	-	5.0	-	-	5.0	-	-	5.0	-	-
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, аймгийн хэмжээнд хэлэлцүүлэх, зөвлөмж гаргах	2020-2024	2.0	-	-	-	1.0	-	-	-	-	-	1.0	-	-
<b>Зорилт 2: Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлж тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд</b>														
Төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт хандлагыг өөрчлөх чиглэлээр сургалтын удирамж боловсруулан хэрэгжүүлэх	2020-2024	30.0	-	-	-	10.0	-	-	10.0	-	-	10.0	-	-
Жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн шинэлэг дүр	2020-2024	3.0	-	-	-	1.0	-	-	1.0	-	-	1.0	-	-



терхийг бий болгох ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үе шаттайгаар зохион байгуулах															
Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах;	2020-2024	3.0	-	-	-	2.0	-	-	-	-	-	1.0	-	-	
<b>Зорилт 3: Нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, гэр бүлийн харилцаанд эрэгтэй эмэгтэй хүний жендэрийн эрх тэгш оролцоог хангаж, үр шимээс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:</b>															
Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж эрх нь зөрчигдсөн иргэдийг хамгаалах байрны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн зөвлөхийн ур чадвар, ажиллах нөхцөлөөр хангах	2020-2024	5.0	-	-	-	3.0	-	-	2.0	-	-	-	-	-	
Нийт	2020-2024	58.0	-												